



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
БӨМБӨГӨР СУМЫН  
ЗАСАГ ДАРГА**

104 дүгээр байр, Өлзийт-1 гудамж, Задгай 4 дүгээр баг,  
Бөмбөгөр сум, Баянхонгор аймаг, 64175  
Цахим шуудан: Bumbugur.ZDTG@bumbugur.bkh.gov.mn  
Цахим хаяг: bayanhongor.bumbugur.gov.mn

2024 09 19 № 107  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТ Г

Бургас 3 дугаар багт хийгдэх гүн өрмийн  
худгийн техникийн тодорхойлолтыг хүргүүлэв.  
Хавсралт хуудастай.

ДАРГА  М.БАЯРСАЙХАН



842105096

БАТЛАВ  
Засаг дарга *M.B.T.* М.Баярсйхан  
2024 оны 09 дүгээр сарын 18 өдөр

Бөмбөгөр сумын Бургас 3 дугаар багт гаргах гүн  
өрмийн худгийн техникийн тодорхойлолт

2024.09.18.

Задгай

Д/Д	Үзүүлэлтүүд
1.	Геофизикийн хайгуул хийх
1.1.	Геофизикийн хайгуул хийж уст цэгийг тогтоох.
2.	Цооног өрөмдөх, цооногийг тоноглох
2.1.	Цооногийн ашиглалтын ундрага: 1 секундэнд 0,8 литрээс дээш ус өгөх хүчин чадалтай, шинэ худаг, уст цэг гаргасан байх.
2.2.	Суултын яндангийн материал ган, ундны усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн хуванцар хоолой байна.
2.3.	Шүүрийн яндангийн материал ган, ундны усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн хуванцар хоолой байна.
2.4.	Ус өргөх яндангийн диаметр 25 мм-ээс багагүй, материал нь төмөр болон ундны усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн хуванцар хоолой байна. /хүйтний улиралд тэсвэртэй/
2.5.	Ус шүүх хайрга нь шигшсэн, мөлгөр хэлбэртэй, тоосонцор хольцгүй, мөхлөгийн хэмжээ 10-15 мм-ээс томгүй байна.
2.6.	Тунгаагуурын гүн : 2 м-ээс багагүй.
2.7.	Худгийн шавхалт хийж цэвэрлэх хугацаа: 24 цагаас багагүй.
2.8.	Усны чанарын сорилт авах шинжилгээ хийлгэнэ .
2.9.	Худгийг түр хугацааны тагаар тоноглоно.
3.	Худгийн байшин, усан сан, мал услах онгоц, талбай барих.
3.1.	Худгийн байшингийн: <ul style="list-style-type: none"><li>• Хэмжээ /дотор талдаа/: 3м x 3м, ханын өндөр шалнаас дээш 2 м</li><li>• Материал: тоосго, мод, блок</li><li>• Ханын зузаан: 38 см</li><li>• Ханыг дотор талаас нь шавардаж цагаан өнгөөр будна.</li><li>• Худгийн дээр 30см x 30см нээлхийг тохируулан хийнэ. Нээлхийг худаг засварлахад хэрэглэнэ.</li></ul> Худгийн цонх 40x50 см хэмжээтэй, хамгаалтын төмөр сараалжин хаалттай байна. /цонхны байрлал нь мал услах онгоцны чанх харалдаа байрлана./
3.2.	Мал услах онгоцонд ус өгөх хоолой: 60мм диаметртэй, гаднах ханаас 2 м урттай гадагшилсан ган хоолойг цонхон доор гаргана.
3.3.	Ундны ус авах хоолой нь: 60мм диаметртэй, ган хоолойг цонхон доор гаргана /ундны ус авхад тохиромжтой байдлаар уртыг сонгох/.
3.4.	40 мм диаметртэй цоорхой генераторын утааг гадагшлуулах зорилгоор генераторын янданд яг тохируулан тохиромжтой байрлалд гаргана.
3.5.	Босоо суурьтай тоноглогдсон, гагнаж хийсэн, дотор талыг зэврэлтээс хамгаалсан 1,5 м-ээс багагүй багтаамжтай ган усан сан, дээгүүрээ модон тагтай байна.
3.6.	Мал услах онгоцны: <ul style="list-style-type: none"><li>• Хэмжээ : 9 м-ээс багагүй урттай, 400 мм-ийн голчтой хагас цилиндр</li><li>• Материал : ган яндан хоолой буюу цутгамал төмөр бетон</li></ul> Услах талбай нь худгийн байшин болон мал услах онгоцтой харьцуулахад бага зэрэг налуу байдлтай хийгдэх бөгөөд үлдэгдэл ус болон асгарсан ус юүлэгдэхэд тохиромжтой байна.
	4. Худгийн насос, бага оврын генератор, цахилгаан утас, хянах самбар
4.1.	Гүний насос: ISO9001 стандартын шаардлага хангасан. Монгол орны уур амьсгалын нөхцөлд тохирсон байна.

4.2.	Цахилгаан утас: 3 салаа, худагт ашиглах шаардлага хангасан Насосноос хянах самбар хүртэл /залгаагүй/, ус өргөх янданд 2м тутам хавчиж /туузаар ороож болохгүй/ тогтооно.
4.3.	Хянах самбар: Асаах унтраах товчлууртай, насоос ажиллаж буйг-ногоон, хүчдэл буйг-улаан гэрлээр асаах индикатортой, насоос ажиллуулах асаагууртай байна.
4.4.	Бага оврын генератор: Бензинээр ажилладаг /ISO стандартын шаардлага /Монгол орны уур амьсгалын нөхцөлд ашиглах боломжтой байх.
5. Худгийн ажлыг дуусгаж хүлээлгэж өгөх	
5.1.	Талбай цэвэрлэнэ. /өрөмдлөгийн шлам, барилгын болон ахуйн хог хаягдал гэх мэт.
5.2.	Худаг гүний насос, генератор ажиллуулах, үйлчилгээ хийх талбайн сургалт хийнэ.
5.3.	Худгийн паспорт бичиж өгнө.

ТОДОРХОЙЛОЛТ ГАРГАСАН: БЭЛЧЭЭР ГАЗАР ТАРИАЛАН ХАРИУЦСАН  
МЭРГЭЖИЛТЭН



Б.БОЛОРЦЭЦЭГ